# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 23 өдөр Дугаар А/58 Мандалговь

Байгууллагын залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 217 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайдын 2021 оны 05 дугаар сарын 17-ны А/72 тоот тушаал, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ны А/48 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал, санаачилгыг дэмжих болон тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг байгуулж, хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгууллагын залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх хөгжил оролцоо, санал санаачлагыг дэмжих болон тэдний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн тэргүүн (Р.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ГАНЗОРИГ

0820070004
9034137 СБТ11714

481190115